



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Б.СЭРГЭЛЭНБААТАР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 572

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Сэргэлэнбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011071657

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 210494951515 бүртгэлийн дугаартай Баттөмөр овогтой Сэргэлэнбаатарын Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Сэргэлэнбаатарын мөрийн хөтөлбөр 2 хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч “Б.Сэргэлэнбаатар”-т

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН 37 ДУГААР ЗҮЙЛИЙН 37.5 -Д ЗААСАН ДҮГНЭЛТ ГАРАХТАЙ ХОЛБОГДУУЛАН
БАЯНДУН СУМААС БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Б.СЭРГЭЛЭНБААТАРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

№	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Хамрах хугацаа	Шаардагдах санхүүгийн эх үүсвэр (Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 20.2.1-20.2.6 дахь заалт)	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн нийт дүн / сая төгрөгөөр /	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ төсвийн жил тус бүрээр / сая төгрөгөөр /				Тайлбар
					2025	2026	2027	2028	
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Угтамын рашаан сувиллыг дэд бүтцэд холбох	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	12 тэрбум	-	6 тэрбум	6 тэрбум	-	
2	Айл өрхүүдийг төвлөрсөн халаалтанд үе шаттайгаар холбоно	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	1 тэрбум	-	400 сая	300 сая	300 сая	
3	Алслагдсан нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	1 тэрбум		500 сая	500 сая		
4	Мах махан бүтээгдэхүүн	2025-2028	20.2.1. Улсын болон	1,3 тэрбум					Хувийн хэвшил,

Б.Н

	боловсруулах стандарт үйлдвэр байгуулна		орон нутгийн төсөв;						хоршоо хөгжүүлэх сангийн санхүүжилт
5	Сумын төвийн бетон замын ажлыг үргэлжлүүлнэ.	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	4.3 тэрбум	1 тэрбум	1 тэрбум	1 тэрбум	1.3 тэрбум	
6	Сумын төвийн ус зайлуулах суваг шуудуу шинээр байгуулах	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	9 тэрбум	2 тэрбум	2 тэрбум	3 тэрбум	2 тэрбум	
7	Улз голын төмөр бетон гүүр шинээр тавих	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	4 тэрбум	-	4 тэрбум	-	-	
8	Алслагдсан бэлчээрийг усжуулах	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	200 сая	50 сая	50 сая	50 сая	50 сая	
9	Хогийн цэгийг стандартын дагуу болгох ажлыг үргэлжлүүлнэ.	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;	250 сая	100 сая	150 сая	-	-	
10	Спорт заал	2025-2028	20.2.1. Улсын болон орон нутгийн төсөв	2,7 тэрбум	1.5 тэрбум	1.2 тэрбум	-	-	
	Бүгд дүн								

Б.Н